



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
“БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 6/78

Бор-Өндөр

Ажилчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2023 оны 12 дугаар сард албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргээ хариуцлагатай, чанартай гүйцэтгэн, идэвхи санаачлага, үр бүтээлтэй ажилласан үйлчилгээний ажилчдад ур чадварын нэмэгдлийг хавсралтад дурдсан хувь хэмжээний дагуу олгосугай.

2. Ур чадварын нэмэгдлийг хавсралтад дурдсан нэрс, хувийг баримтлан 2023 оны 12 дугаар сард бодож олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.АМАРЖАРГАЛ

